



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Орон нутгийн төсвийн орлогын
төлөвлөгөөний хуваарийг бүртгэх, орлогын
гүйцэтгэлд хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн "Төсвийн сар улирлын хуваарь батлах тухай" А/07 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлаар батлагдсан 2024 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр сар бүр жигд ханган биелүүлж ажиллахыг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга (Ч.Оюунжаргал), Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга (Н.Мөнгөнтуяа) нарт даалгасугай.

2. Орон нутгийн орлогын 2024 оны төлөвлөгөөг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэхийг Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч (Б.Баатарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн дарга (Ш.Мөнгөнцэцэг)-д үүрэг болгосугай

ДАРГА



М.ТУЯАЦЭЦЭГ